

“ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ” ХК-ИАС
КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖЛЫН ТАЙЛАН
(2024 оны 4 дүгээр улирлын байдлаар)

2024.12.31Улаанбаатар хот

Компанийн засаглалын үйл ажиллагааны тайлангийн маягт			
“Компанийн засаглалын кодекс”-ын зарчмын зүйл тус бүрээр үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайланг дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэнэ. Кодексын хэрэгжилтийг олон улсад түгээмэл тогтсон “Хэрэгжүүл, эсвэл тайлбарла” гэсэн зарчмын дагуу тайлагнахдаа кодекс дүрдсэн зарчмын зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын ямар арга хэмжээ авсныг тайлбар хэсэгт нарийвчлан тайлбарлана. НЭГДҮГЭЭР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна			
Д/д	Компанийн засаглалын кодексын зарчмын заалтууд	Хэрэгжилт	Тайлбар
1	2	3	4
1	1.1. Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.	Журамд 1.1-д заасан чиг үүргийг тодорхойлсон	ТУЗ-ийн 2022 оны 21 дүгээр тогтоолоор “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-ыг шинэчлэн баталсан ба хэрэгжилтийг ханган ажиллаж байна
2	1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна.	Журам, бодлогын баримт бичигт 1.2-т заасан асуудлыг тусгасан	ТУЗ-ийн 2022 оны 23 дугаар тогтоолоор “ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх журам”-ыг, 2023 оны 05 дугаар тогтоолоор “Залгамж халааны бодлогын баримт бичиг”-ийг тус тус шинээр баталсан ба хэрэгжилтийг ханган ажиллаж байна
3	1.3. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, өөрийн цахим хуудсанд байршуулна.	Компанийн цахим хуудсанд 1.3-т заасан асуудлыг байршуулсан	Компанийн www.mongolianre.com цахим хуудсанд “ТУЗ-ийн болон хороодын тайлан” гэсэн цэс шинээр нэмж, холбогдох тайланг байршуулсан ба хэрэгжилтийг ханган ажиллаж байна
4	1.4. Компани нь ТУЗ-ийн болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримт бичигтэй байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэр зэрэг асуудлыг тусгана.	Журамд 1.4-т заасан асуудлыг тусгасан	ТУЗ-ийн 2022 оны 22 дугаар тогтоолоор “ТУЗ-ийн дэргэдэх хороодын ажиллах журам”-ыг шинээр баталсан ба хэрэгжилтийг ханган ажиллаж байна
5	1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.	ТУЗ-ийн гишүүнд түүний чиг үүрэг, компанид мөрдөгдөх хууль тогтоомжтой анх томилогдоход танилцуулдаг	Энэ хэсэгт дурдсан асуудлыг хэрэгжүүлж ажилладаг. “Санхүүгийн боловсролын зангилаа” ТББ-тай хамтран 2025 оны 1 сард “Комплаенсын удирдлага” сэдэвт сургалтад ТУЗ-ийн гишүүдийг бүрэн

			хамруулахаар төлөвлөн ажиллаж байна
6	1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажилладаг	Энэ хэсэгт дурдсан асуудлыг хэрэгжүүлж ажилладаг. ТУЗ-ийн нарийн бичгийн даргын чиг үүргийг “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-д нарийвчлан тусгаж өгсөн
ХОЁРДУГААР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ			
ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ			
7	2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.	2.1-д заасныг хэрэгжүүлж ажилладаг	ТУЗ-ийн 9 гишүүний 3 нь хараат бус гишүүн байдаг ба хэрэгжилтийг ханган ажиллаж байна
8	2.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.	2.2-т заасныг хэрэгжүүлж ажилладаг. Хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус хараат бус гишүүн байдаг	Хорооны үйл ажиллагааг “ТУЗ-ийн дэргэдэх хороодын ажиллах журам”-аар тусгайлан зохицуулсан ба хэрэгжилтийг ханган ажиллаж байна
9	2.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.	2.3-т заасныг хэрэгжүүлж ажилладаг. Хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус хараат бус гишүүн байдаг	Хорооны үйл ажиллагааг “ТУЗ-ийн дэргэдэх хороодын ажиллах журам”-д тусгасан. ТУЗ-ийн 2023 оны 08 дугаар тогтоолоор “Цалин, урамшууллын бодлогын баримт бичиг”-ийг шинээр баталсан ба хэрэгжилтийг ханган ажиллаж байна
10	2.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.	2.4-т заасныг хэрэгжүүлж ажилладаг. Хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус	Хорооны үйл ажиллагааг “ТУЗ-ийн дэргэдэх хороодын ажиллах журам”-д тусгасан. ТУЗ-ийн 2023 оны 05 дугаар тогтоолоор “Залгамж халааны бодлогын баримт бичиг”-ийг шинээр баталсан ба хэрэгжилтийг ханган ажиллаж байна
11	2.5. ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршлага бүхий бүрэлдэхүүнтэй байна.	2.5-д заасныг хэрэгжүүлж ажилладаг. Эрсдэлийн хороог байгуулсан	Хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байдаг. Хорооны үйл ажиллагааг “ТУЗ-ийн дэргэдэх хороодын ажиллах журам”-д тусгасан ба хэрэгжилтийг ханган ажиллаж байна
ГУРАВДУГААР ЗАРЧИМ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ			
ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана			
12	3.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	3.1-д заасныг хэрэгжүүлж ажилладаг	ТУЗ-ийн 2022 оны 28 дугаар тогтоолоор “Мэдээллийн ил тод байдлын журам”-ыг шинээр баталсан ба хэрэгжилтийг ханган ажиллаж байна
13	3.2. ТУЗ нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.	3.2-т заасныг хэрэгжүүлж ажилладаг	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нийцүүлэн компанийн цахим хуудсанд холбогдох дүрэм, журмыг байршуулсан ба хэрэгжилтийг ханган ажиллаж байна
14	3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.	3.3-т заасныг хэрэгжүүлж ажилладаг	Компанийн үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлан болон бусад тайланг хууль тогтоомжид заасан хугацаанд нь гаргаж, холбогдох байгууллагад тогтмол тайлагнадаг ба хэрэгжилтийг ханган ажиллаж байна
ДӨРӨВДҮГЭЭР ЗАРЧИМ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО			
ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана			

15	4.1. ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, хөндлөнгийн аудиторыг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, журмын хэрэгжилтэд хяналт тавина.	4.1-д заасныг хэрэгжүүлж ажилладаг	Энэ хэсэгт дурдсан асуудлыг ТУЗ-ийн 2024.12.30-ны өдрийн 20 дугаар тогтоолоор “ТУЗ-ийн дэргэдэх хороодын ажиллах журам”-д нэмэлт, өөрчлөлтөөр оруулсан ба хэрэгжилтийг ханган ажиллаж байна
16	4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.	4.2-т заасныг хэрэгжүүлж ажилладаг	Энэ хэсэгт дурдсан асуудлыг хэрэгжүүлж ажилладаг. Шаардлагатай тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох бүрэн боломжтой
17	4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж тэдгээрт орсон өөрчлөлтийг тухай бүр мэдэгдэнэ.	Дотоод аудитын нэгжтэй	Энэ хэсэгт дурдсан асуудлыг хэрэгжүүлж ажилладаг. ТУЗ-ийн 2024.12.30-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор “Дотоод аудитын журам”-ыг шинэчлэн баталсан ба хэрэгжилтийг ханган ажиллаж байна
ТАВДУГААР ЗАРЧИМ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина			
18	5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	Эрсдэлийн удирдлагын нэгжтэй	Үйл ажиллагааг нь зохицуулсан журам, аргачлал, зааврыг ТУЗ-ийн 2023 оны 03, 04 дүгээр тогтоолоор шинээр болон шинэчлэн баталсан ба хэрэгжилтийг ханган ажиллаж байна
19	5.2. ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.	5.2-т заасныг хэрэгжүүлж ажилладаг. Эрсдэлийн хороог байгуулсан	Хорооны дарга нь хараат бус гишүүн байдаг. Хорооны үйл ажиллагааг “ТУЗ-ийн дэргэдэх хороодын ажиллах журам”-д тусгасан ба хэрэгжилтийг ханган ажиллаж байна
20	5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.		Энэ хэсэгт дурдсан асуудлыг хэрэгжүүлж ажиллана
21	5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	5.4-т заасныг хэрэгжүүлж ажилладаг	ТУЗ-ийн 2022 оны 27 дугаар тогтоолоор “Комплаенсын хяналтын журам”-ыг шинээр баталсан ба хэрэгжилтийг ханган ажиллаж байна
ЗУРГААДУГААР ЗАРЧИМ. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна			
22	6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.	6.1-д заасныг хэрэгжүүлж ажилладаг	ТУЗ-ийн гишүүдэд олгох цалинг Сангийн сайдын 2017 оны 137 дугаар тушаалаар баталсан ба хэрэгжилтийг ханган ажиллаж байна
23	6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримт бичигт тусгана.	6.2-т заасныг хэрэгжүүлж ажилладаг	ТУЗ-ийн 2023 оны 08 дугаар тогтоолоор “Цалин, урамшууллын бодлогын баримт бичиг”-ийг шинээр баталсан ба хэрэгжилтийг ханган ажиллаж байна
24	6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.	Холбогдох журамд 6.3-т заасан асуудлыг тусгасан	ТУЗ-ийн 2022 оны 24 дүгээр тогтоолоор “Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журам”-ыг шинээр баталсан ба хэрэгжилтийг ханган ажиллаж байна
ДОЛООДУГААР ЗАРЧИМ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ			
25	7.1. Компани нь ТУЗ-өөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь	Компани нь холбогдох хууль тогтоомжийн хүрээнд оролцогч	ТУЗ-ийн 2024 оны 09 дүгээр тогтоолоор “Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлогын баримт бичиг”-ийг

	оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.	талуудын эрх ашгийг хүндэтгэн хамтран ажилладаг	шинээр баталсан ба хэрэгжилтийг ханган ажиллаж байна
26	7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.	“Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд 7.2-т заасан асуудлыг тусгасан	Энэ хэсэгт дурдсан асуудлыг хэрэгжүүлж ажилладаг. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланг www.mongolianre.com цахим хуудсанд нээлттэйгээр тогтмол байршуулж байна
27	7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.	7.3-т заасныг хэрэгжүүлж ажилладаг	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нийцүүлэн компанийн www.mongolianre.com цахим хуудсанд нээлттэй мэдээллийг тогтмол байршуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна
28	7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.	Холбогдох журамд 7.4-т заасан асуудлыг тусгасан	Гүйцэтгэх захирлын 2023 оны А/08 дугаар тушаалаар “Ажилтнуудаас гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-ыг шинээр баталсан ба хэрэгжилтийг ханган ажиллаж байна
НАЙМДУГААР ЗАРЧИМ. КОМПАНИЙН СОЁЛ ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно			
29	8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	8.1-д заасныг хэрэгжүүлж ажилладаг	ТУЗ-ийн 2022 оны 29 дүгээр тогтоолоор “Ажилтны ёс зүйн дүрэм”-ийг шинэчлэн баталж, компанийн www.mongolianre.com цахим хуудсанд байршуулсан ба хэрэгжилтийг ханган ажиллаж байна
30	8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл үлээгчийн” тогтолцоотой байна.	8.2-т заасныг хэрэгжүүлж ажилладаг	Энэ хэсэгт дурдсан асуудлыг “Комплаенсын хяналтын журам”-д тусгасан ба хэрэгжилтийг ханган ажиллаж байна
31	8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.	8.3-т заасныг хэрэгжүүлж ажилладаг	Энэ хэсэгт дурдсан асуудлыг “Ажилтны ёс зүйн дүрэм”-д тусгасан ба хэрэгжилтийг ханган ажиллаж байна
ЕСДҮГЭЭР ЗАРЧИМ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана			
32	9.1. Компани хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудад зориулан өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан тухай бүр хүргэнэ.	9.1-д заасныг хэрэгжүүлж ажилладаг	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нийцүүлэн компанийн www.mongolianre.com цахим хуудсанд нээлттэй мэдээллийг тогтмол байршуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна
33	9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба хөрөнгө оруулагчидтай харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.	9.2-т заасныг хэрэгжүүлж ажилладаг. цахим хуудаснаас гадна фэйсбүүк (facebook), твиттэр (twitter), ютүб (youtube) цахим сувгийг хөгжүүлж, мэдээлэл солилцох боломжтой болсон	ТУЗ-ийн 2024 оны 10 дугаар тогтоолоор “Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр”-ийг шинээр баталсан ба хэрэгжилтийг ханган ажиллаж байна. “Мэдээллийн ил тод байдлын журам”-д “Үндэсний давхар даатгал ХК” гэсэн нэртэй фэйсбүүк (facebook) хуудас, “MongolianRe” гэсэн нэртэй твиттэр (twitter) хуудас, “Mongolian Re” гэсэн нэртэй ютүб (youtube) хуудастай байхаар тусгасан.
34	9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.	Холбогдох журамд 9.3-т заасан асуудлыг тусгасан	ТУЗ-ийн 2023 оны 07 дугаар тогтоолоор “Хувьцаа эзэмшигчдийн хурлын үйл ажиллагааг зохион байгуулах журам”-ыг шинээр баталсан ба

			хэрэгжилтийг ханган ажиллаж байна
35	9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтэцтэй холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.		Нээлттэй хувьцаат компани болсон тохиолдолд энэ хэсэгт дурдсан асуудлыг хэрэгжүүлж ажиллана
36	9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба түүний хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.	Холбогдох журамд 9.5-д заасан асуудлыг тусгасан	ТУЗ-ийн 2023 оны 01 дүгээр тогтоолоор “Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам”-ыг шинээр баталсан ба хэрэгжилтийг ханган ажиллаж байна
<i>Санамж: Компани нь засаглалын зарчмуудыг Монгол Улсын үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад үнэт цаасаа бүртгүүлсэн бүх хуулийн этгээд хэрэгжүүлнэ. Тухайлбал, “МХБ” ХК-ийн 1-р ангилалд бүртгэлтэй үнэт цаас гаргагч нь кодексын зүйл тус бүрээр энэхүү маягтын дагуу хэрэгжилт, эсхүл тайлбарыг бүрэн, 2-р ангилалд бүртгэлтэй этгээд 95 хувийг хангасан байна. Хэрэв дээр дурдсан шалгуурыг хангаагүй буюу хэрэгжүүлээгүй эсвэл тайлбарлаагүй тохиолдолд Тухайн ХК-ийн МХБ-ийн бүртгэлийн ангиллыг бууруулах үндэслэл болох ба нөгөө талаас хөрөнгө оруулагч шийдвэр гаргахад нөлөөлөх шалтгаан болно.</i>			